

бүрэлдэхүүнтэй байхаар заагдсан боловч одоогийн байдлаар зураг, төсөв бүрэн хийгдээгүй, баталгаажаагүй.

- Барилгын хөгжлийн төвөөс ажлын гүйцэтгэлд хийсэн хяналтаар гүйцэтгэгч байгууллага барилга угсралтын ажлын явцын акт, тэмдэглэл үйлдээгүй, материалын гарал, үүслийн баримт бичгийг бүрдүүлээгүй, гадна шугам сүлжээний хоолойг норм стандартын шаардлага хангахуйц гүнд суулгаагүй, газар шорооны ажлыг технологийн дагуу гүйцэгээгүй, явган хүний замыг хүйтний улиралд хийснээс болж, суулт өгсөн, захиалагчаас тавьсан шаардлагыг биелүүлээгүй зэрэг зөрчлийг удаа дараагийн хяналтаар гаргаж байсан.


Энэ нь Иргэний хуулийн 350.1.1-д “гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэх” гэсэн заалтыг зөрчжээ.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т “Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ыг үндэслэн ТОГТООХ НЬ:


- Иргэний хууль болон “Гэр хорооллын дахин төлөвлөлт, инженерийн дэд бүтцийн зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэх” гэрээний тусгай нөхцлийн 46.1-д “алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн дунгийн 0.05 хувь, нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн дунгийн 10 хувиас хэтрэхгүй” гэж заасныг үндэслэн тооцсон алданги болох 500.0 /таван зуун сая/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төв төрийн сан дах улсын төсвийн орлогын 900000601 тоот дансанд 2015 оны 9 дүгээр сарын 15-ны дотор төвлөрүүлж улсын төсвийн орлого болгох,
- Тогтоосон төлбөрийг барагдуулах арга хэмжээ авч, биелэлтийг 2015 оны 9 дүгээр сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Р.Эрдэнэбүрэн, СЭЗХ-ийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэч Д.Хасар нарт хариуцуулав.

#### АКТЫГ

ТОГТООСОН:



ЗӨВШӨӨРСӨН:





**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

**АКТ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр  
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2015.06.05 № 1/24 УАГ-ГАГ/2015/01-ГА

**Төлбөрийн акт тогтоох тухай**

Барилга хот байгуулалтын сайдын багцад улсын төсвийн хөрөнгөөр 2014 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд аудит хийх явцад Монгол Дайвин ХХК-тай холбоотой дараах зөрчил илэрлээ.

Монгол дайван ХХК БХБЯ-ны захиалгаар Хэntий аймгийн Биндэр, Өмнөговь аймгийн Цогт-Овоо, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Дорнод аймгийн Баян-Уул гэсэн 4 сумын төвийн шинэчлэлтийн ажил, мөн “Гэр хорооллын инженерийн шугам, сүлжээ Хөөсгөл, Мөрөн сум” 5.0 тэрбум, “Гэр хороололын дахин төлөвлөлт, инженерийн дэд бүтэц Улаанбаатар” 5.0 тэрбум, нийт 30.0 тэрбум төгрөгийн 6 ажлын гүйцэтгэгчээр ажиллаж байна. Дээрх ажлуудын гэрээний хугацаа 1 нь 2013 онд, 5 нь 2014 онд дууссан боловч ажлын гүйцэтгэл 20-70 хувьтай, бүх гэрээ тулхүүр гардуулах нөхцөлтэй бөгөөд зураг, төсвийг нь мэргэжлийн байгууллагаас баталаажуулаагүй байна.

Тус компаний 2013 оны 11 дүгээр сарын 20-нд гэрээ байгуулсан Сонгинохайрхан дүүргийн 30 дугаар хорооны 168 айлын амины орон сууцны хорооллын оршин суугчдыг дулаан, халуун, хүйтэн усаар хангаж, бохир усыг татан зайлцуулах, авто болон явган хүний зам, гэрэлтүүлэг, хашаа барих, сууцнуудын гадна фасадыг жигд болгох “Гэр хорооллын дахин төлөвлөлт, инженерийн дэд бүтцийн зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэх” 5.0 тэрбум төгрөгийн ажлыг дуусгах хугацаа 2013 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болж, гэрээний хугацаа сунгагдаагүй, ажлын гүйцэтгэлийн чанар хангалтгүй, 70 орчим хувийн гүйцэтгэлтэй, 90 хувийн санхүүжилт авсан байна.

Дээрх ажлыг гүйцэтгэх явцад дараах зөрчлүүд гарчээ. Үүнд:

1. БХБЯ-наас 2013 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр боловсруулж, баталгаажуулсан зургийн даалгаврын дагуу гүйцэтгэгч гэрээ байгуулнаас хойш 6 сарын хугацаанд зураг, төсвийг боловсруулах бөгөөд зураг төсөл нь улсын экспертизээр баталгаажсан, ашиглагч байгууллагаар батлуулсан M1:1000 масштабтай газрын зургийн тодотгол, инженер геологийн дүгнэлт, хавсралтын хамт, инженерийн шугам сүлжээний иж бүрэн зураг, төсөв, авто зам, явган хүний зам, талбайн гэрэлтүүлэг, хашааны зураг төсөв гэсэн

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН  
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА Р.ЭРДЭНЭБҮРЭН ТАНАА